

# ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

## Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

### 1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон Төлөөлөгчид хөдөөгийн багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг Нөмрөг, Баянхайрхан, Тэс, Баянтэс, Асгат сумдад зохион байгуулж, 16 багийн 1426 иргэдэд эрүүл мэндийн болон ахуйн үйлчилгээг үзүүллээ.



Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн эрүү, хэв журам, нөхцөл байдлын мэдээг нэгтгэж дүн шинжилгээ хийж ажиллалаа.

Аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссоос улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хуулиудыг сурталчлах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах, нөхөн олговрын материалыг бүрдүүлэхэд нь хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж Алдархаан сумын иргэн Д.Цэрэндорж, Нөмрөг сумын иргэн М.Даваабаатар нарын ирүүлсэн хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжилсан.

### 1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Завхан аймагт Сурган заах арга зүйн байгууллага үүсэж хөгжсөний 60 жилийн ойг 2019 оны 08 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ.

Ойн арга хэмжээнд аймгийн Засаг дарга Д.Батсайхан, БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монгол улсын Ардын багш Ү.Маам, Монгол улсын гавьяат багш Ө.Чулуунбаатар, С.Цэрэндулам, У.Дэмбэрэлнямбуу, А.Дэмбэрэлнямбуу, Н.Цэрэндолгор, Доктор, дэд профессор Б.Дэмид, сурган заах арга зүйн байгууллагад ажиллаж байсан арга зүйч мэргэжилтэн н.Сольхүү, Б.Лхамрагчаа, Я.Нарангэрэл, М.Гүрсэд, Л.Базардаргиа, Д.Түмэн-Өлзий, Д.Чойжилсүрэн ажилтан Д.Лхүндэв, Д.Даваа, М.Маналжав, н.Чимэгмаа нар болон Монгол улсын гавьяат багш Р.Маабазар агсаны гэргий Д.Чанцаа, хүү “Бодрол” сангийн тэргүүн М.Батболд, аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, соёлын төвийн эрхлэгч зэрэг 350 гаруй эрхэм хүндэт зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцлоо.

Мөн Завхан аймагт эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг 2019 оны 08 сарын 09-10-ны өдрүүдэд амжилттай тэмдэглэн өнгөрүүллээ. Эрүүл мэндийн салбарын 90 жилийн ойг тохиолдуулан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 4, Алтан гадас одон 6, Хөдөлмөрийн хүндэт медаль 6, Засгийн газрын шагнал Эрүүлийг хамгаалахын Тэргүүний ажилтан цол тэмдэгээр 122, хүндэт жуух бичгээр 94 болон бусад шагналыг олгож нийтдээ 500 гаруй албан хаагчыг шагнаж урамшуулсан байна.

Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйчилгээний жил” болгон зарласан тогтоолыг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын “Ард иргэдээ сонсох VI аян”-ны хүрээнд “Төрийн үйлчилгээг багт” арга хэмжээг 2019 оны 08 дугаар сарын 03-20-ны өдрийг хүртэлх хугацаанд 23 сумын хөдөөгийн 88 багт зохион байгуулсан.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Балхярваагаар ахлуулсан ажлын хэсэг Асгат, Баянтэс, Баянхайрхан, Тэс, Нөмрөг сумдад, Засаг дарга Д.Батсайханаар ахлуулсан ажлын хэсэг Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Идэр сумдад, Засаг даргын орлогч Б.Ариунаагаар ахлуулсан ажлын хэсэг Цэцэн-Уул, Сонгино, Сантмаргаз, Түдэвтэй, Яруу сумдад, Засаг даргын Тамгын газрын дарга Л.Лхамсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Алдархаан,

Ургамал, Дөрвөлжин, Завханмандал, Эрдэнэхайрхан сумдад нийт 110 гаруй хүний бүрэлдэхүүнтэй төрийн үйлчилгээг багийн иргэдэд хүргэсэн.

Арга хэмжээний үеэр аймгийн Засаг даргын 2019 оны хагас жилд хэрэгжүүлсэн ажлын тайланг тавьж, аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, нийгмийн салбарт хэрэгжүүлж буй ажлын талаар нийтэлсэн Өдрийн сонины 10800 ширхэг тусгай дугаарыг тарааж, төрийн албан хаагчдын ажлыг үнэлэх үнэлгээний хуудас бөглүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд болон бусад санал, хүсэлтийг авч, хөдөөгийн 88 багийн Иргэд Нийтийн хурлын дарга, Багийн Засаг дарга, багийн эмч нарт Жи мобайлын суурин утас антены хамт гардуулж, ажил үйлсээрээ амжилт гаргасан иргэдийг аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшууллаа.

Мөн 7000 гаруй иргэдэд Улсын 2, 3 дугаар төв эмнэлэг, хавдар судлалын үндэсний төв зэрэг томоохон эмнэлгийн эмч нар эмэгтэйчүүд, ЭХО, хавдар, дотор, шүд, хүүхэд зэрэг мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулсан. Мөн хөнгөлөлттэй эм, урлаг соёлын үзүүлбэр, үсчний үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор нийт 10,000 гаруй мянган иргэд үйлчилгээ авсан байна.

Донойн нисэх онгоцны буудлын онгоц хөөрч, буух 1860 у/м хатуу хучилттай зурвас болон Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын ажлуудыг улсын комисс ажиллаж хүлээн авлаа.

Мөн БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр барих Улиастай сумын 25 мВт-ын дулааны станцын зураг төсөв хийх ажлын хэсэг орон нутагт ажиллаж, шугамын трасс, дулаан дамжуулах төвийн байршил зэргийг газар дээр нь хэмжилт хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд орон нутгаас шаардлагатай холбогдох мэдээлэл, судалгааг гаргаж өгсөн.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**2.1.Татварын орлого:** Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 139 хувийн биелэлттэй, 7 тэр бум 712.8 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 39.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.2 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 26.2 хувь, бусад нэр төрөл 31.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 68.2 хувь буюу 5 тэрбум 263.3 сая төгрөгийг орон нутгийн орлого, 31.8 хувь буюу 2 тэр бум 449.4 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 7 сарын байдлаар гүйлгээнд 3 тэрбум 313 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 39.5 мянган иргэний 101.1 тэрбум төгрөг

байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 18.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр 69.9 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 11.2 хувь буюу 8.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.50%, Хас банк 1.58%, Төрийн банк 1.44%

### **Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:**

**3.1.** Улсын хэмжээнд зохион явуулж буй “Улсын дугаар-2019”, "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2019" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Завхан аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагчид, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар Их-Уул, Тосонцэнгэл, Нөмрөг, Сонгино, Тэлмэн сумдын улсын чанартай авто замд тогтмол хяналт, шалгалт хийж, хөдөлгөөнд оролцож яваа тээврийн хэрэгслүүдийн арлын дугаарыг гэрчилгээтэйн тулгаж, хянах самбарын дээр болон хөдөлгүүрийн баруун хэсэгт байрлах, урд хаалганы багана дээрхи арлын дугаартай тулгаж, улсын дугаар бүдгэрсэн, буруу байрлуулсан зэрэг бүртгэлийн зөрчилтэй жолооч нарт арга хэмжээ авч ажиллалаа.

**3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:** Аймгийн хэмжээгээр 146 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 29.5 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 34.2 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 36.3 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 7-оор буюу 5 хувиар өссөн байна.

Эхний 7 сард гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 49 хүн гэмтэж 212.9 сая төгрөгийн хохирол учирсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр 8166 зөрчил илрүүлж, 273 хүн эрүүлжигдэн, 170 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 5057, баривчлагдсан хүн 36-аар буурч, эрүүлжигдсэн хүн 131-ээр буурсан байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 53 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6 пунктээр буурсан байна.

**3.3. Архивын ажлын мэдээлэл:** Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 4 хөмрөг, 4 данс, 58 хадгаламжийн нэгжийн 2338 хуудас баримтыг сканердаж, 4 хөмрөг 4 дансны 58 хадгаламжийн нэгж, 2338 хуудас баримтыг photoshop программд засварлалаа.

14 хөмрөг, 14 данс, 147 хадгаламжийн нэгжийн удирдлагын баримт бичгийн хүрээнд 5000 хуудас баримтаас 6474 заалт, 11097 хүний нэр, 440 газарзүйн нэр программд шивж 147 файл үүсгэн эх баримтыг холболоо.

136 иргэн, 2 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 258 баримт шүүж, 55 хуулбар, 63 лавлагаа, 22 тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

Төрийн архивыг 2019 онд нөхөн бүрдүүлэх төлөвлөгөөний дагуу 1 хөмрөгийн 53 хадгаламжийн нэгж хүлээн авлаа.

**3.4.Онцгой байдал:** Сум орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэх талаар Дэлхийн зөн



ОУБ-ын Завхан хангай орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, болон Их-Уул сумын ЗДТГазартай



хамтран тус сумыг Сум орон нутгийн хэмжээнд жишиг "Гал түймэр унтраах бүлэг" болгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан Тосонцэнгэл сум дахь

Онцгой байдлын хэлтэс, "Дэлхийн зөн Монгол" ОУБ-ын Завханхангай ОНХХ-тэй хамтран 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Их-Уул сумын "Объектын гал түймэр унтраах сайн дурын бүлэг"-ийг чадавхжуулах сургалтыг хамтран зохион байгуулж "Дэлхийн зөн Монгол" ОУБ-ын Завханхангай ОНХХ-с 4 сая төгрөгийн үнэ өртөг бүхий 8 нэр төрлийн Гал түймэр унтраах багаж хэрэгслүүдийг хүлээлгэн өгч 6 цагийн танхимийн сургалт, 2 цагийн гал түймэр унтраах дадлага сургалтад 25 албан тушаалтан, иргэдийг хамруулан зохион байгуулсан.

Улсын нөөцийн салбарын чиглэлээр Сонгино сум дахь шатахууны цэгийн



алба хаагчид 50 м<sup>3</sup>-ын 2 ширхэг далд савыг суллан Улаанбаатар-Увс аймгийн чиглэлийн хатуу хучилттай зам тавьж байгаа компанийн кранаар гаргуулсан.

Мөн агуулахын 200 м<sup>3</sup> болон 700 м<sup>3</sup>-ын босоо савнууд, 50 м<sup>3</sup>-ын далд, 25 м<sup>3</sup>-ын савнуудад Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш

доктор, дэд профессор Оросоогоор метал хийцийн оношлогоо хийлгэсэн.

Улсын нөөцийн салбарын өвс тэжээлийн цэгүүдэд байгаа үлдэгдэл өвс тэжээл болон шинээр бүрдүүлэх өвс тэжээлийн тооцоог гаргаж Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн газрын холбогдох мэргэжилтэнд цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

Сонгино сумд шатахуун түгээх станц болон Аврах бүлгийн байр барих загвар зургийг аймгийн ерөнхий архитекороор батлуулан архитектур төлөвлөлтийн

даалгавар гаргуулан Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн газрын холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

2019 оны 07 сарын 24, 25-ний өдрүүдэд Алдархаан сумын нутаг Донойн хөндийд Морин спорт уяачдын холбооноос санаачлан зохион байгуулсан “ОЧИРВААНИЙ ШИГШМЭЛ ХУРД-2019” хурдан морины уралдаан, 2019 оны 08 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Эрдэнэхайрхан сумын Улаагчны хар нуурын эрэг дээр зохион байгуулсан Залуучуудын чуулга уулзалтад оролцогчдын аюулгүй байдлыг хангаж онцгой байдлын газраас 4 автомашин, 32 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Энэ сард график төлөвлөгөөний дагуу ОБЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Улиастай болон Тосонцэнгэл сумдад үйл ажиллагаа эрхэлж буй Авто үйлчилгээний 13 газарт Гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион явууллаа.

Дээрх хяналт шалгалтын хүрээнд нийт 60 зөрчил илрүүлж газар дээр нь 11 арилгуулж хяналт шалгалтын хүрээнд илэрч буй зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага нийт 5, мэдэгдэл 1 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар нийт 38 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Заавал биелүүлэх албан шаардлага 5, Танилцуулга 1, Мэдэгдэл 2, Ажлын байрны галын аюулгүй байдлын зөвшөөрөл 5, Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 3, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 2 удаа, Гомдол мэдээлэл хүлээж авахаас татгалзах тогтоол 2, Барилга байгууламж хүлээж авах улсын комисс 4, Барилгын зураг төсөл 3 тус тус хянаж шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газруудын удирдлагуудад танилцуулж зөрчлийг арилгуулах талаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.


#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**4.1. Боловсрол, соёлын чиглэлээр:** Түүхт 60 жилийн ойн хүрээнд “БОЛОВСРОЛ, СОЁЛЫГ ТҮҮЧЭЭЛСЭН БҮТЭН ЖАРНЫ ТҮҮХ” түүхэн замналын номыг шинээр бүтээлээ. Номд ерөнхий боловсролын 29 сургууль, 40 цэцэрлэг, 23 соёлын төв, соёл урлагын 3 байгууллага, мэргэжлийн 4 сургуулийн түүхийг нэгтгэн бичиж салбарын хэмжээнд түүхийн нэгдсэн номтой болсноороо онцлог юм.





“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ” сэдэвт онол практикийн үндэсний 1-6-р бага хуралд манай аймгийн 179 илтгэл багтаж байна. Дээрх илтгэлүүдээс Хичээлийн судалгааны үндэсний эксперт, зөвлөхүүд тодорхой шалгуурт тэнцсэн 60 илтгэлээс 48 шилдэг өгүүлэл, илтгэлийн эмхтгэлийг 300 ширхэгийг хэвлэн гаргалаа.



“БАГШЛАХ АРГА ЗҮЙ I”, “БАГШЛАХ АРГА ЗҮЙ-II”, “БАГШЛАХ АРГА ЗҮЙ-III” сайн хөтөлбөрийн эмхэтгэлийг нэгтгэж түгээн дэлгэрүүллээ.

“ЗАВХАН АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ: ТҮҮХЭН ЗАМНАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА” онол практикийн бага хурал зохион байгууллаа.

Онол практикийн бага хурал 2 үе шаттай явагдаж, I шатанд “Завханыхны эрдэм номын уламжлал ба аймгийн сургалт-арга зүйн байгууллагын хөгжил дэх хүний хүчин зүйл” Н.Бэгз/академич/, “Хөгжүүлэх сургалтын арга зүй” Б.Дэмид /Боловсрол судлалын ухааны доктор, дэд профессор/ гэсэн хүндэтгэлийн илтгэл тавигдсан. Илтгэлийг тодорхой шалгуурын дагуу үнэлэн илтгэгчдийг “Боловсролын ахмадууд” ТББ-аас 2.0 сая төгрөгөөр урамшууллаа.

Ойд зориулан Э.Пагмаагийн үг, Ё.Эрдэнэбаатарын ая “Гэгээн эрдмийн өргөө” дуутай боллоо. Мөн энэ үеэр эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 29 багш, ажилтныг Алтан гадас, Хөдөлмөрийн хүндэт медаль, Боловсролын тэргүүний ажилтан, Соёлын тэргүүний ажилтан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Хүндэт жуух бичгээр зэрэг төрийн одон медалиар шагналаа.

“Үе залгамжлагч” хүндэтгэлийн концертод 37 багш ажилтан, 21 суралцагч оролцож, Хөгжимт жүжгийн театрын уран сайхны удирдаач В.Энхтайваны найруулгаар хувьсгалын өмнөх, хувьсгалын дараах, орчин үеийнх гэсэн 3 үеийг харуулсан зохиомжтойгоор тоглолоо.

Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтыг сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлж, орон нутагт түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 20-23-нд Завхан аймгийн Улиастай суманд амжилттай зохион байгуулагдлаа.

БМДИ-ийн хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалтын албаны дарга Ш.Оюунцэцэг багшаар ахлуулсан үндэсний сургагч 36 багш сургалтыг зохион

явууллаа. Сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 19 судлагдахууны 662 багш, удирдах ажилтан, 40 цэцэрлэгийн 200 багш, эрхлэгч хамрагдаж, сургалтын сайжруулсан хөтөлбөрийн агуулгатай танилцлаа. Энэ сургалт нь өмнө хэрэгжиж байсан сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг сайжруулсан хөтөлбөрийн агуулгатай харьцуулан дадлага ажил дээр тулгуурлан явагдсанаараа онцлог байлаа.

“Сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтаар багш нар сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын өргөсөл, гүнзгийрэл, залгамж холбоо, багтаамжийг судалж ойлгох, сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн удирдамж, сурах бичгийн уялдаа холбоог шинжлэн, сургалтад хэрэглэх, арга зүй, үнэлгээ, хичээлд суурилсан сургалт, үйл ажиллагааг төлөвлөх зэрэг чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн сургалт явагдлаа.

**4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр:** Аймгийн Засаг дарга НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах хамтын гэрээний хүрээнд эрүүл мэндийн салбарт эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилт бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж энэхүү хөтөлбөрийн дагуу 08 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд “Нярайн тулгамдсан асуудлууд” сэдэвт сургалтыг зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын 35 эмч мэргэжилтнүүд оролцон шинэ мэдлэг, дадлагыг эзэмшсэн байна.

ЭМЯ –ны Эмнэлгийн тусламжийн газрын эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эх хүүхдийн үндэсний төвийн Ерөнхий зөвлөх болон бусад мэргэжилтний баг 8 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд ажиллаж аймгийн Нэгдсэн эмнэлгийн Амаржих газар, эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинет, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Жирэмсний хяналт болон Эх хүүхэд нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”-ийн дунд хугацааны үнэлгээг хийж, эх барихын чиглэлээр холбогдох эмч мэргэжилтэнд зөвлөгөө, зөвлөмжийг өгсөн байна.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 1,189,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр баригдах Алдархаан сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилгыг тендерийг Эрүүл мэндийн яамны Бодлого зохицуулалтын газар дээр зохион байгуулснаар “Арьконстракшн” ХХК шалгарч ЭМЯамтай гэрээгээ байгуулсан ба 2019 оны 9-р сард ажлаа эхэлнэ.

Глобаль сангийн хөрөнгө оруулалтаар Халдварт сүрьеэгийн эмнэлгийн салхивч агааржуулалтын системийн 60,0 сая төгрөгийн ажил хийгдэж ашиглалтад оруулсан байна.



## **Нийгмийн даатгал, халамж**

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний VII сарын байдлаар 28,0 мянган хүнд 26,1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 3 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна. Эхний VII сарын байдлаар 65132 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 61134 буюу 93,8 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 3998 иргэн буюу 6,2 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 25318 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 865.2 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 2008.4 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 713.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 166 сая төгрөг тус тус зарцуулж нийт 29071.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 49,8 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 24,2 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 40,1 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 37 хувиар тус тус давуулан биелүүлж байна.

## **Хөдөлмөр эрхлэлт**

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 719 болж, өнгөрсөн оны мөн үеэс 18,5 хувиар буюу 146 хүнээр нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд 387 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 53,8 хувийг эзэлж байна.

**Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:** Аймгийн хэмжээнд 7 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны 1444.8 мянган хээлтэгч малын 1033.2 мянга (71.5%) нь төллөжээ. Гүүний 70.0 хувь, үнээний 76.2 хувь, ингэний 45.8 хувь, эм хонины 75.8 хувь, эм ямааны 65.1 хувь нь төллөж байна. Төллөлтийн хувь өмнөх оноос 18.6 пунктээр буурсан байна. Гарсан төлийн 96.9 хувь буюу 1001.2 мянган төл бойжиж байна. Төл бойжилтын хувь 0.7 пунктээр буурсан байна.

Тэс сумын Нисэг багийн нутагт цусан халдварт өвчин гарч сумын засаг даргын А/53 тоот захирамжийн дагуу хязгаарлалтын дэглэмийг 14 хоногийн хугацаатай тогтоож мал бүхий 8 өрхийн малд эрүүл мэндийн үзлэг шинжилгээг хийж малчин, мал бүхий иргэдэд холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллалаа. Мөн аймгийн мал эмнэлгийн газрын гоц халдварт, халдварт өвчин гарсан үед зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, хувцас эм биобэлдмэлийн нөөцөөс 50 кг хлорын шохойг Тэс сумын мал эмнэлгийн тасагт хүргүүлж, өвчин гарсан суурьт ариутгал халдваргүйжүүлэлт хийж нийт 1240 м<sup>2</sup>талбай хамрагдлаа.

НҮБ-ын ХХААБ-ын Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлж байгаа "Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх" (ТСР/MON/3701) төслөөс орон нутгийн малын эмч нарт зориулсан "ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН СУДАЛГАА" сургалтыг 2019 оны 8 дугаар сарын 21-23- ны өдрүүдэд зохион байгуулж сумдын мал эмнэлгийн тасгийн нийт 15 тархвар зүйч эмч хамрагдлаа.

Мал эмнэлгийн лабораторийн ариун цэвэр магадлан шинжилгээний тасагт: 12 дээж, материал ирж нийт 300 литр сүү, 315 кг маханд холбогдох стандарт арга зүйн дагуу шинжилгээг хийж хариуг лабораторийн эрхлэгчээр баталгаажуулан холбогдох аж, ахуй нэгж иргэнд хүргүүлсэн.

Мал эмнэлгийн лабораторийн төлөвлөгөөт ажлын хүрээнд Цагаанхайрхан, Цагаанчулуут, Отгон, Шилүүстэй сумдын мал сүрэгт хээлтэгч малын бруцеллөз өвчний шинжилгээнд нийт 800 хонь, 720 ямаа, 320 үнээ, адууны халдварт цус багадаа, адууны нийлүүлгийн өвчин, цусны паразитын дээжинд 100 адуунаас цус авч түрхэц бэлтгэн бүртгэл хөтлөн ийлдсийг нь ялган шинжилгээ хийхэд бэлэн болсон. Адууны ям, үхрийн сүрьеэ өвчний харшил сорилыг 100 үхэр, 100 адуунд хийж үр дүнг хүргүүлсэн.

**Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

**6.1.Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулж буй "Хандлагаа өөрчилъе" багц ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Улиастай суманд "Ногоон паспорт-Ногоон төгөл" байгуулах ажлыг зохион байгуулж талбайн байршлыг сонгон, кадастрын зургийн хэмжилт хийлгэн, холбогдох мэдээллийн БОАЖЯ-нд хүргүүлсэн.

БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газартай хамтран 2016-2018 онуудад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Идэр сумдад хийгдсэн ойжуулалтын ажилтай танилцан тухайн ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн инжнерүүд, сумдын байгаль хамгаалагч нарт мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

2019 оны 8 сарын 16-26-нд Улаагчны Хар нуурын байгалийн цогцолбор газарт зохион байгуулагдсан "Баруун бүсийн залуучуудын чуулга уулзалт"-ын үеэр аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, маршрут, аймгийн 9-н гайхамшиг, баруун аймгуудад аялал жуулчлал хөгжих боломжийн талаарх мэдээллийг хүргэж, сурталчилсан.

Тарваган тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 8 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд Тэлмэн сумын 9 иргэний агнасан 58 тарвагыг хураан авч устгал хийх ажлыг зохион байгуулсан.

Мөн Цагаанхайрхан сумаас байгалийн ургамлыг хууль бусаар түүсэн Улиастай сумын 2 иргэний 537 кг арцанд экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох, шийдвэрлэх ажлыг зохион байгуулж байна.

Бэлчээрийн даац тодорхойлох хээрийн явуулын судалгааг гүйцэтгэсэн.

**6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7 сарын байдлаар оны үнээр 13 тэрбум 795.4 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 56.5 хувиар буюу 7796.2 сая төгрөгөөр өссөн нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 8649.2 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 5146.2 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 28.1 хувийг, хүнсний үйлдвэрлэл 31.1 хувь, боловсруулсан мах үйлдвэрлэл 23.9 хувь, хувцас үйлдвэрлэл 9.3 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 5.0 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 1.0 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.1 хувь, гурил үйлдвэрлэл 0.1 хувь, Болк тоосго үйлдвэрлэл 0.6 хувь, арьс шир үйлдвэрлэл 0.2 хувь, бусад үйлдвэрлэл 0.6 хувийг тус тус эзэлж байна.

**6.3. Дэд бүтцийн чиглэлээр:** Шинээр баригдаж байгаа барилга угсралт, их засварын ажилд батлагдсан график төлөвлөгөөний дагуу үе шатны техникийн хяналтыг гүйцэтгэж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алдархаан сумд 50 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2018-2019 онд “Алтанхарш” ХХК барьж гүйцэтгэн 2019.08.19-нд улсын комиссд хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.

Тэс сумын ЗДТГ-ын конторын барилга угсралтын ажлыг “Аз өрнөх” ХХК гүйцэтгэж 2019.07.04-нд, Яруу сумын сургуулийн Спорт заал, хичээлийн байрны их засварын ажлыг “Боду” ХХК гүйцэтгэж 2019.07.18-нд, Тосонцэнгэл сумын Тарвагатай нурууны хамгаалалтын захиргааны байрыг “Бийрийн уулс” ХХК гүйцэтгэж 2019.07.25-нд, Цэцэн-Уул сумын 160 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга угсралтын ажилд улсын комисс зохион байгуулж ашиглалтад оруулаад байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Дөрвөлжин сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлыг “Бэрсүм” ХХК гүйцэтгэж 2019.07.03-нд, Цэцэн-Уул сумын 250 суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажлыг “Цэгц” ХХК гүйцэтгэж 2019.07.26-нд улсын комиссд хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.

Хойд сумдад баригдах Соёл амралтын хүрээлэнгийн ажил нэг маягийн зургаар хийгдэж байгаа ба Цэцэн-Уул сумын Соёл амралтын хүрээлэн ашиглалтад орж Тосонцэнгэл, Их-Уул сум ашиглалтад оруулах мэдүүлгээ өгөөд байна.

Улиастай сумд баригдаж байгаа 800 хүний суудалтай Хөгжимт жүжгийн театрийн барилга угсралтын ажлын тайзны, зеритлийн хэсгийн 1,2-р гадна дотор өрлөгийн ажил, дотор шавардлагын ажил хийгдэж галерейн хэсэг, зрителийн хэсгийн төмөр ферм, хучилтын ажил хийх бэлтгэл ажлаа хангаж суурин кран угсарч хучилтын ажилд ашиглах түр шат бэлтгэж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилга угсралтын ажлыг “Ханжаргалант стоунс” ХХК гүйцэтгэж подвол, 1-р давхрын төмөр бетон цутгалт хийгдэж 2-р давхрын хэв хашмал армотурчлалын ажил хийгдэж байна. Авто вокзал оношлогооны төвийн барилга угсралтын ажил төмөр бетон каркасны ажил дуусч, өрлөг дээврийн ажил хийгдэж байна.

Сантмаргаз сумын 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга, Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил, Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн барилга, Шилүүстэй сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Их-Уул сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг 2019.10-р сард ашиглалтад оруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Баянтэс сумын 300 хүний суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажил удаашралтай явагдаж гүйцэтгэгч компанид ажлаа эрчимжүүлэх албан тоот хүргүүлсэн.

Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, Улиастай сумын 2-р сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, Эрдэнэхайрхан сумын ЗДТГ-ын конторын барилга, Идэр сумын Соёлын төвийн барилга угсралтын ажил зөвшөөрлөө авч ажлаа эхлээд байна.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**